



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/А-24

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол, 2021 оны 78 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дэх заалт, "Боловсролын чанарыг сайжруулах" хөтөлбөрийн 7.2.5 дахь заалт, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг үндэслэн зохион байгуулж буй "Улсын төрөлжсөн олимпиад"-ын зардалд шаардагдах 25,000,000 (хорин таван сая) төгрөгийг "Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр"-ийн батлагдсан зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2. Олимпиадыг чанартай зохион байгуулж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т үүрэг болгосугай.

3. Захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР